



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС

ӨРХ, ХҮН АМЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ 2025



НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН

ХҮН АМ



2025

Улаанбаатар хот
2026 он

ТАНИЛЦУУЛГЫГ БЭЛТГЭСЭН:

Б.ШИНЭЦЭЦЭГ

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

ТАНИЛЦУУЛГЫГ ХЯНАСАН:

Г.ЧИНЖАРГАЛ

ХЭЛТСИЙН ДАРГА

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг
27-р хороо, Замчдын гудамж-3
Засаг даргын Тамгын газрын байр 112, 114 тоот
Утас: 11-301637, 70122688
Цахим хаяг: bayangol@nso.mn
Цахим хуудас: <http://www.1212.mn>
<http://www.ubstat.mn>
<http://www.bgd.mn>



АГУУЛГА

НЭГ. ХҮН АМЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ	9
ХОЁР. ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨН	18
ГУРАВ. НИЙГМИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ	21
ДӨРӨВ. АРГА, АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР	29

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

МУ	Монгол Улс
ҮСХ	Үндэсний Статистикийн хороо
ТЕК	Төрөлтийн ерөнхий коэффициент
НБЕК	Нас баралтын ерөнхий коэффициент
ГЕК	Гэрлэлтийн ерөнхий коэффициент
ЦЕК	Цуцлалтын ерөнхий коэффициент



ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 1. МОНГОЛ УЛС, НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ӨРХ, ХҮН АМЫН ТОО, улс, нийслэл, жил бүрийн эцэст	9
ХҮСНЭГТ 2. СУУРИН ХҮН АМЫН ТОО, хороогоор, жил бүрийн эцэст	10
ХҮСНЭГТ 3. ӨРХ, ХҮН АМЫН ТОО, дундаж ам бүл, хүн амын нягтрал, 2025 оны жилийн эцэст	11
ХҮСНЭГТ 4. ХҮН АМЫН ЖИЛИЙН ДУНДАЖ ТОО, жил бүрийн эцэст	12
ХҮСНЭГТ 5. ТӨРӨЛТ, НАС БАРАЛТ, хүн амын цэвэр өсөлт, жил бүрийн эцэст	12
ХҮСНЭГТ 6. ХҮН АМЫН ДУНДАЖ НАСЛАЛТ, улс, нийслэл, жил бүрийн эцэст	14
ХҮСНЭГТ 7. СУУРИН ХҮН АМЫН ТОО, хүйс, насны бүтцээр, жил бүрийн эцэст	15
ХҮСНЭГТ 8. ХҮН АМЫН ТОО, насны бүлэг, хүйсээр, 2025 оны жилийн эцэст	16
ХҮСНЭГТ 9. ХҮН АМ ЗҮЙН АЧААЛАЛ, жил бүрийн эцэст	17
ХҮСНЭГТ 10. ТӨРӨЛТ, НАС БАРАЛТЫН ТОО, төрөлт, нас баралтын ерөнхий коэффициент, жил бүрийн эцэст	18
ХҮСНЭГТ 11. АМАРЖСАН ЭХИЙН ТОО, боловсролын түвшнээр, жил бүрийн эцэст	19
ХҮСНЭГТ 12. НАС БАРСАН ХҮНИЙ ТОО, насны бүлгээр, жил бүрийн эцэст	19
ХҮСНЭГТ 13. ГЭРЛЭЛТ, ЦУЦЛАЛТЫН ТОО, ерөнхий, тусгай коэффициент, жил бүрийн эцэст	20
ХҮСНЭГТ 14. ХАГАС, БҮТЭН ӨНЧИН ХҮҮХДИЙН ТОО, хороогоор, жил бүрийн эцэст	23
ХҮСНЭГТ 15. ХАГАС, БҮТЭН ӨНЧИН ХҮҮХДИЙН ТОО, насны ангиллаар, жил бүрийн эцэст	24
ХҮСНЭГТ 16. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТОО, өвчний төрөл, хэлбэрээр, жилийн эцэст	25
ХҮСНЭГТ 17. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТОО, хороогоор, жил бүрийн эцэст	26
ХҮСНЭГТ 18. ӨРХИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эцэст	27
ХҮСНЭГТ 19. ИХЭР ХҮҮХДИЙН ТОО, хүүхдийн тоогоор, жил бүрийн эцэст	28

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ 1. ХҮН АМЫН ТОО, жилийн дундаж өсөлтийн хувь, жил бүрийн эцэст	10
ЗУРАГ 2. ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2015, 2025 оны жилийн эцэст.....	13
ЗУРАГ 3. ХҮН АМЫН ДУНДАЖ НАСЛАЛТ, хүйс, улс, нийслэлээр, жил бүрийн эцэст	14
ЗУРАГ 4. ХҮН АМЫН НАСНЫ БҮТЭЦ, дүнд эзлэх хувиар, жил бүрийн эцэст	14
ЗУРАГ 5. ХҮН АМ ЗҮЙН АЧААЛАЛ, улс, дүүргээр, жил бүрийн эцэст	17
ЗУРАГ 6. ТӨРСӨН ХҮҮХДИЙН ТОО, эхийн насны бүлгээр, 2025 оны жилийн эцэст	17
ЗУРАГ 7. НАС БАРСАН ХҮНИЙ ТОО, хүйсээр, жил бүрийн эцэст.....	20
ЗУРАГ 8. ГЭРЛЭЛТ, ГЭР БҮЛ ЦУЦЛАЛТЫН ТОО, жил бүрийн эцэст	20
ЗУРАГ 9. ГЭРЛЭЛТЭЭ БҮРТГҮҮЛСЭН ХҮНИЙ ТОО, насны бүлгээр, 2025 оны жилийн эцэст...	21
ЗУРАГ 10. ҮРЧЛЭГДСЭН ХҮҮХЭД, нийслэл, дүүрэг, жил бүрийн эцэст	22
ЗУРАГ 11. ХАГАС, БҮТЭН ӨНЧИН ХҮҮХДИЙН ТОО, жил бүрийн эцэст	22
ЗУРАГ 12. ӨНЧИН ХҮҮХДИЙН ТОО, хороогоор, хүйсээр, 2025 оны жилийн эцэст	24
ЗУРАГ 13. ӨРХ ТОЛГОЙЛСОН ХҮНИЙ ТОО, хүйсээр, жил бүрийн эцэст	24
ЗУРАГ 14. ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭЦЭГ, ЭХИЙН ТОО, хороогоор, жил бүрийн эцэст	25
ЗУРАГ 15. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭД, шалтгаанаар, дүнд эзлэх хувиар, 2025 оны жилийн эцэст	26



НЭГ. ХҮН АМЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Баянгол дүүргийн хүн ам өмнөх оны мөн үеэс 5363 (2.1%) хүнээр буурсан байна.

Баянгол дүүрэгт 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар 71792 өрхөд 254710 хүн байнга оршин сууж байгаагийн 120522 (47.3%) нь эрэгтэй, 134188 (52.7%) нь эмэгтэй байна. Өнгөрсөн 2024 оны үзүүлэлтээс 421 (0.6%) өрх өссөн бол 5363 (2.1%) хүнээр буурсан байна.

ХҮСНЭГТ 1.


МОНГОЛ УЛС, НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ӨРХ, ХҮН АМЫН ТОО, улс, нийслэл, жил бүрийн эцэст

Үзүүлэлт	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
	мян.өрх							
Өрхийн тоо	59.5	63.0	63.1	62.8	65.5	69.5	71.4	71.8
Нийслэлийн өрхийн тоо	387.5	411.4	414.3	412.5	431.0	465.1	475.1	490.5
Нийслэлийн дүнд эзлэх хувь	15.4	15.3	15.2	15.2	15.2	15.0	15.0	14.6
Улсын нийт өрх	894.5	897.4	908.7	920.2	941.5	983.5	997.0	1 011.1
Улсын дүнд эзлэх хувь	6.7	7.0	6.9	6.8	7.0	7.1	7.2	7.1
	мян.хүн							
Хүн амын тоо	226.9	225.8	232.2	237.0	247.5	253.6	260.1	254.7
Нийслэлийн хүн ам	1 444.7	1 466.1	1 503.3	1543.4	1 600.5	1 644.9	1 682.0	1 673.3
Нийслэлийн дүнд эзлэх хувь	15.7	15.4	15.4	15.4	15.5	15.4	15.5	15.2
Улсын нийт хүн ам	3 186.3	3 197.0	3 260.5	3319.5	3 375.9	3 404.0	3 448.8	3 425.2
Улсын дүнд эзлэх хувь	7.1	7.1	7.1	7.1	7.3	7.4	7.5	7.4

2025 оны байдлаар Баянгол дүүрэгт Монгол улсын нийт хүн амын 7.4 хувь, Нийслэл хотын хүн амын 15.2 хувь нь тус тус амьдарч байна.

Хүн амын үндсэн үзүүлэлтүүд болох төрөлт, нас баралт, шилжилт хөдөлгөөнөөр хүн амын тоог тодорхойлдог. Хүн амын тооны өөрчлөлт нь улс

орны тухайн үеийн нийгэм, эдийн засгийн хөгжил, ард түмний аж байдлын түвшин, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж зэрэг олон хүчин зүйлтэй уялддаг.

ЗУРАГ 1. ХҮН АМЫН ТОО, жилийн дундаж өсөлтийн хувь, жил бүрийн эцэст

Хүн амын жилийн дундаж өсөлтийн хурдыг сүүлийн 9 жилийн байдлаар авч үзвэл онд 3.3 хувь, 2021 онд 2.1 хувь, 2022 онд 4.3 хувь, 2023 онд 2.4 хувь, 2018, 2020 онуудад 2.5 хувиар, 2024 онд 2.8 хувиар тус тус өссөн байна. Харин 2019

онд 0.5 хувиар, 2025 онд 2.1 хувиар буурчээ. 2022 онд хүн амын дундаж өсөлтийн хурд хамгийн их байсан бол 2021 онд хамгийн бага буюу 2.1 хувь байна.

ХҮСНЭГТ 2. СУУРИН ХҮН АМЫН ТОО, хороогоор, жил бүрийн эцэст

Хороо	2019	2020	2021	2022	2023	2024	2025	2025 2024
	тоо							хувь
Дүүргийн дүн	225 840	231 517	236 385	246 886	252 979	260 073	254 710	-2.1
I хороо	16 858	9 614	9 976	9 873	9 966	9 931	9 265	-6.7
II хороо	8 615	8 798	9 067	9 190	9 115	9 413	9 256	-1.7
III хороо	16 076	16 828	17 712	6 578	7 062	7 304	7 327	0.3
IV хороо	22 018	14 143	13 982	8 102	7 558	7 746	7 559	-2.4
V хороо	11 673	12 328	12 498	9 115	8 562	8 460	7 936	-6.2
VI хороо	16 421	16 525	16 510	11 102	10 783	10 711	10 027	-6.4
VII хороо	12 465	12 269	11 750	5 895	7 069	7 246	7 039	-2.9
VIII хороо	12 306	12 467	12 708	7 777	7 890	8 126	8 019	-1.3
IX хороо	6 576	6 673	6 700	8 086	8 246	8 625	8 342	-3.3
X хороо	7 853	7 929	8 269	8 080	7 786	7 786	7 643	-1.8
XI хороо	6 686	6 576	6 625	6 153	6 313	6 392	6 321	-1.1
XII хороо	10 351	10 729	10 574	5 605	5 480	5 418	5 312	-2.0
XIII хороо	4 571	4 923	5 032	5 132	4 634	4 725	4 884	3.4
XIV хороо	4 071	4 372	4 551	4 633	4 470	4 337	4 115	-5.1
XV хороо	4 365	4 465	4 380	4 649	4 346	4 493	4 738	5.5
XVI хороо	5 850	5 912	5 769	5 509	5 124	5 058	4 791	-5.3
XVII хороо	10 169	10 171	10 815	8 766	8 243	8 179	7 630	-6.7
XVIII хороо	11 690	11 907	12 100	9 110	10 073	10 488	10 098	-3.7
XIX хороо	5 767	5 724	7 073	7 429	7 599	7 797	7 637	-2.1
XX хороо	10 224	10 711	10 633	4 060	3 677	3 471	3 238	-6.7
XXI хороо	8 399	8 519	8 334	7 940	7 109	6 804	6 606	-2.9
XXII хороо	7 776	8 009	7 887	7 799	7 390	7 284	7 045	-3.3
XXIII хороо	5 060	5 536	5 438	6 774	6 334	6 223	5 927	-4.8
XXIV хороо	-	6 406	7 506	9 248	13 355	14 825	15 429	4.1
XXV хороо	-	10 645	11 158	7 048	7 346	7 546	7 286	-3.4
XXVI хороо	-	0 000	0 000	14 446	16 773	18 493	18 329	-0.9

XXVII хороо	-	0 000	0 000	6 116	5 878	6 431	6 488	0.9
XXVIII хороо	-	0 000	0 000	7 337	7 083	7 094	6 965	-1.8
XXIX хороо	-	0 000	0 000	7 267	8 400	8 651	9 296	7.5
XXX хороо	-	0 000	0 000	6 375	6 032	6 259	5 883	-6.0
XXXI хороо	-	0 000	0 000	4 829	5 869	6 156	6 170	0.2
XXXII хороо	-	0 000	0 000	6 522	7 211	7 430	7 362	-0.9
XXXIII хороо	-	0 000	0 000	6 584	6 600	6 727	6 357	-5.5
XXXIV хороо	-	0 000	0 000	4 419	4 265	4 444	4 390	-1.2

Дүүргийн өрх, хүн амын тоо сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж хороодын иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний хүртээмжид ачаалалтай байгаа тул төрийн үйлчилгээг иргэдэд хурдан шуурхай, чирэгдэлгүй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор өрх, хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, барилгажилт, дахин төлөвлөлт зэргийг

харгалзан Нийслэлийн Баянгол дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 04/03 тоот тогтоолоор 3, 4, 5, 6, 7, 8, 11, 12, 17, 18, 20, 23, 25 дугаар хороодын хилийн цэсийг шинэчлэн шинээр 26, 27, 28, 29, 30, 31, 32, 33, 34 дүгээр хороодыг байгуулан нийт 34 хороотой болсон.

ХҮСНЭГТ 3. ӨРХ, ХҮН АМЫН ТОО, дундаж ам бүл, хүн амын нягтрал, 2025 оны жилийн эцэст

Хороо	2025				Дундаж ам бүл	Хүн амын нягтрал
	Өрх	Хүн ам	Эр	Эм		
	тоо					1 га талбайд ногдох хүний тоо
Дүүргийн дүн	71 792	254 710	120 522	134 188	3.5	86
I хороо	2 638	9 265	4 316	4 949	3.5	372
II хороо	2 612	9 256	4 299	4 957	3.5	286
III хороо	2 030	7 327	3 471	3 856	3.6	171
IV хороо	1 923	7 559	3 553	4 006	3.9	364
V хороо	2 309	7 936	3 685	4 251	3.4	281
VI хороо	3 037	10 027	4 760	5 267	3.3	294
VII хороо	1 809	7 039	3 258	3 781	3.9	447
VIII хороо	2 148	8 019	3 699	4 320	3.7	392
IX хороо	2 556	8 342	4 011	4 331	3.3	162
X хороо	2 103	7 643	3 704	3 939	3.6	102
XI хороо	1 733	6 321	3 141	3 180	3.6	79
XII хороо	1 542	5 312	2 529	2 783	3.4	512
XIII хороо	1 195	4 884	2 243	2 641	4.1	269
XIV хороо	1 157	4 115	1 953	2 162	3.6	292
XV хороо	1 210	4 738	2 221	2 517	3.9	329
XVI хороо	1 469	4 791	2 389	2 402	3.3	84
XVII хороо	2 167	7 630	3 524	4 106	3.5	626
XVIII хороо	2 694	10 098	4 656	5 442	3.7	420
XIX хороо	1 909	7 637	3 573	4 064	4.0	308
XX хороо	0 984	3 238	1 669	1 569	3.3	3
XXI хороо	2 052	6 606	3 236	3 370	3.2	74
XXII хороо	1 888	7 045	3 474	3 571	3.7	66
XXIII хороо	1 679	5 927	2 944	2 983	3.5	72
XXIV хороо	4 699	15 429	7 256	8 173	3.3	210
XXV хороо	2 109	7 286	3 510	3 776	3.5	63
XXVI хороо	5 147	18 329	8 742	9 587	3.6	287

XXVII хороо	1 489	6 488	3 008	3 480	4.4	184
XXVIII хороо	2 039	6 965	3 285	3 680	3.4	538
XXIX хороо	2 725	9 296	4 316	4 980	3.4	33
XXX хороо	1 767	5 883	2 779	3 104	3.3	285
XXXI хороо	1 846	6 170	2 846	3 324	3.3	385
XXXII хороо	1 988	7 362	3 429	3 933	3.7	511
XXXIII хороо	1 918	6 357	2 974	3 383	3.3	411
XXXIV хороо	1 221	4 390	2 069	2 321	3.6	557

Дүүргийн суурин хүн амын тоо өмнөх оноос 5.3 (2.1%) мянган хүнээр буурчээ. Хүн амын нягтралаар авч үзвэл: Дүүргийн 1 га нутаг дэвсгэрт 2012 онд 65, 2013 онд 68, 2017 онд 75, 2018 онд 77, 2019 онд 76, 2020 онд 79, 2021 онд 80, 2022 онд 84, 2023 онд 86, 2024 онд 88, 2025 онд 86 хүн оршин сууж байна. Нэг га газар

нутагт ногдох хүний тоо буюу хүн амын нягтрал 2021 оны байдлаар 12 дугаар хороонд 577, 7 дугаар хороонд 335, 18 дугаар хороонд 384 хүн төвлөрч байсан бол хилийн цэс өөрчлөгдсөнтэй холбоотойгоор 2025 оны байдлаар 7 дугаар хороонд 626, 28 дугаар хороонд 538, 34 дүгээр хороонд 557 хүн хамгийн их төвлөрсөн байна.

Дүүргийн хүн амын жилийн дундаж тоо нь өнгөрсөн оноос 866 (0.3%) хүнээр өссөн байна.

ХҮСНЭГТ 4. ХҮН АМЫН ЖИЛИЙН ДУНДАЖ ТОО, жил бүрийн эцэст

Үзүүлэлт	2019	2020	2021	2022	2023	2024	2025
	тоо						
Жилийн эхний хүн ам	226 869	225 840	232 179	237 047	247 548	253 641	260 073
Жилийн эцсийн хүн ам	225 840	232 179	237 047	247 548	253 641	260 073	254 710
Хүн амын жилийн дундаж тоо	226 355	229 009	234 613	242 297	250 594	256 857	257 392

Хүн амын өсөлт нь төрөлт, нас баралтын зөрүүгээр тодорхойлогдох ердийн цэвэр өсөлт, шилжин ирэлт, шилжин явалтын зөрүүгээр тодорхойлогдох механик цэвэр өсөлт гэсэн үзүүлэлтүүдээр тодорхойлогдож байдаг.

ХҮСНЭГТ 5. ТӨРӨЛТ, НАС БАРАЛТ, хүн амын цэвэр өсөлт, жил бүрийн эцэст

Үзүүлэлт		Хэмжих нэгж	2021	2022	2023	2024	2025
Баянгол	Төрсөн хүүхэд	тоо	5 149	4 433	4 384	3 882	3 614
	Нас барсан хүн	тоо	1 269	1 410	1 342	1 354	1 370
	Ердийн цэвэр өсөлт	тоо	3 880	3 023	3 042	2 528	2 244
	Ердийн цэвэр өсөлтийн коэффициент	тоо	16.6	12.5	12.2	16.6	12.2
Нийслэл	Төрсөн хүүхэд	тоо	33 784	30 835	30 538	27 878	26 361
	Нас барсан хүн	тоо	9 503	8 660	8 554	8 848	8 739
	Ердийн цэвэр өсөлт	тоо	24 281	22 175	21 984	19 030	17 622
	Ердийн цэвэр өсөлтийн коэффициент	хувь	15.0	14.1	13.8	15.0	13.8
Цэвэр өсөлтөд дүүргийн эзлэх хувийн жин		хувь	15.4	16.0	13.6	13.7	16.0

Жил ирэх тусам ердийн цэвэр өсөлт, түүний коэффициент өсөж байсан боловч сүүлийн жилүүдэд буурах хандлагатай байна. Мөн нийслэлийн ердийн цэвэр өсөлтөд тус дүүрэг сүүлийн жилүүдэд 13-16 орчим хувийг эзэлж байна. 2025 онд тус дүүрэгт 3614 хүүхэд төрсний 1685 (46.6%) нь эмэгтэй хүүхэд байна.


Хүн амын насны бүтцийг судлах нь тухайн хүн ам зүйн түүхэн замналыг харах, одоогийн үйл явцыг үнэлж, дүгнэх, цаашдын чиг хандлагыг тодорхойлох бололцоо олгодгоороо ихээхэн ач холбогдолтой юм. Өөрөөр хэлбэл хүн амын нас, хүйсийн бүтцийн өөрчлөлтийн чиг хандлагыг харгалзан улс орныхоо нийгэм, эдийн засгийн урт, богино хугацааны бодлого, хөтөлбөр боловсруулах үндэслэл болдог. Хүн амын

төрөлт, нас баралтын түвшнээс хамааран тухайн улсын хүн амын насны бүтэц өөрчлөгдөж байдаг. Хүн амын хэдэн хувь нь хүүхэд, залуучууд, идэр насныхан эсвэл хөгшчүүд байгаагаас хамааран нийгэм, эдийн засгийн хөгжлийн хандлагад нөлөөлдөг.

Хүн амын нас, хүйсийн суварга дунд хэсгээрээ өргөссөн хэлбэртэй байгаа нь хүн амын насны бүтэц идэршиж буйг илтгэнэ. 2025 оны насны бүтэцтэй харьцуулахад тодорхой өөрчлөлт ажиглагдаж байгаа бөгөөд нийт хүн амд эзлэх 0–4 насны бүлгийн эзлэх хувь буурсан байна. Энэ нь 2015 оноос хойш төрөлтийн түвшин аажмаар буурсантай холбоотой бөгөөд ялангуяа сүүлийн таван жилийн хугацаанд төрөлт буурах хандлага үргэлжилж байгааг харуулж байна.

ЗУРАГ 2.

ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2015, 2025 оны жилийн эцэст



Суварга дээшлэх тусам нарийсаж байгаа нь нас баралт өсөж байгаагаас шалтгаалж байна. Мөн өндөр настай эмэгтэйчүүдийн нас баралт эрэгтэйчүүдийнхтэй харьцуулахад бага байгаа нь суваргаас харагдаж байна. 2025 оны нас хүйсийн суварга дээшлэх тусам нарийсаж

Дундаж наслалт нь шинээр төрсөн хүүхдийн эрүүл мэнд, амьдрах нөхцөл нь цаашид хэвээр хадгалагдана гэж үзвэл түүний үргэлжлэн амьдрах жилээр тооцсон дундаж хугацааг хэлнэ.

байгаа нь зөвхөн төрөлт багасаж байгаа төдийгүй нас нэмэгдэх тусам нас баралт өсөж байгаагаас шалтгаалж байна. Мөн өндөр настай эмэгтэйчүүдийн нас баралт эрэгтэйчүүдийнхтэй харьцуулахад бага байгаа нь суваргаас харагдаж байна.

Өөрөөр хэлбэл, насны бүлэг дэх нас баралтын коэффициентийг үндэслэн тухай хугацаанд шинээр төрсөн хүүхдийн цаашид амьдрах дундаж хугацааг тодорхойлох “таамаглах хэмжигдэхүүн” юм.

ХҮСНЭГТ 6.

ХҮН АМЫН ДУНДАЖ НАСЛАЛТ, улс, нийслэл, жил бүрийн эцэст

Үзүүлэлт	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Улаанбаатар	71.8	72.09	72.32	72.31	72.24	72.45	72.31
Улсын дундаж	70.41	70.71	71.01	71.28	71.50	71.77	72.07
Нийслэл, улсын дунджийн зөрүү	1.39	1.38	1.31	0.82	0.74	0.68	0.24

Дундаж наслалтын үзүүлэлт нь аливаа улс орны эрүүл мэндийн салбарын хөгжлийн хүрсэн түвшнийг харуулдаг чухал үзүүлэлт бөгөөд хүний хөгжлийн индексийн тооцоо, тэтгэврийн нас тогтоох, даатгалын байгууллагуудын эрсдэлийн тооцоо хийх зэрэг төлөвлөлтүүдийг

хийхэд ашиглагддаг. Нийслэлийн хүн амын дундаж наслалт 2025 онд 72.31 болж, өмнөх оноос 0.14 жилээр богиноссон байна. 2019 оны байдлаар Улаанбаатар хотын хүн амын дундаж наслалт улсын дунджаас 1.39 жилээр илүү байсан бол 2025 оны байдлаар 0.24 жилээр илүү болжээ.

ЗУРАГ 3.

ХҮН АМЫН ДУНДАЖ НАСЛАЛТ, хүйс, улс, нийслэлээр, жил бүрийн эцэст




Нийслэлийн хүн амын дундаж наслалтыг хүйсээр нь авч үзвэл шинэ төрсөн эрэгтэй хүүхэд дунджаар 67.7 жил, эмэгтэй хүүхэд 75.6 жил амьдрах магадлалтай байна. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүү 2015 онд 8.8 байсан бол 2025 онд 7.9 болсон байна.

Дундаж наслалт нь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хувьд нэлээд ялгаатай байдгаас уг тооцоог эрэгтэй, эмэгтэй хүн амын хувьд тусдаа хийх нь төлөвлөлтийн олон талын ач холбогдолтой юм.

ЗУРАГ 4.

ХҮН АМЫН НАСНЫ БҮТЭЦ, дүнд эзлэх хувиар, жил бүрийн эцэст



Дүүргийн хэмжээнд хүн амын дунд хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь буурч байгааг харж болно. Нийт хүн амд хөдөлмөрийн насны иргэдийн эзлэх хувь өндөр байх үеийг “Хүн ам зүйн цонх” гэдэг. Энэ үед улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд хүн ам зүйн хүчин зүйл эергээр нөлөөлдөг.

Баянгол дүүргийн нийт хүн амын 57.0 хувийг 35 хүртэлх насны залуучууд эзэлж байна. Тодруулбал нийт хүн амын 38.7 хувь (98574 хүн) нь 0-18 насны хүүхэд, 51.5 хувь (131278 хүн) нь 19-59 насны хүмүүс, 9.8 хувь (24858 хүн) нь 60 ба түүнээс дээш насны өндөр настан тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 7.**СУУРИН ХҮН АМЫН ТОО, хүйс, насны бүтцээр, жил бүрийн эцэст**

Насны бүлэг	2021		2022		2023		2024		2025	
	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй
	тоо									
Дүн	237 047	125 341	247 548	130 577	253 641	133 713	260 073	137 300	254 710	134 188
0-4	26 774	13 002	26 434	12 809	25 804	12 566	24 341	11 827	22 077	10 740
5-9	30 422	14 792	30 896	14 861	31 011	15 047	30 561	14 938	29 306	14 283
10-14	22 250	10 966	24 836	12 238	26 815	13 135	28 879	14 130	30 103	14 749
15-19	12 824	6 337	14 634	7 275	16 233	8 111	18 665	9 326	19 419	9 652
20-24	12 567	6 500	13 022	6 696	12 895	6 678	12 825	6 648	11 286	5 763
25-29	15 862	8 658	15 460	8 351	15 454	8 332	15 515	8 303	14 233	7 527
30-34	23 698	12 755	23 972	12 932	22 638	12 045	21 197	11 336	18 673	9 960
35-39	20 886	11 160	22 660	12 047	23 793	12 599	25 179	13 266	24 820	12 958
40-44	16 482	8 826	17 276	9 218	18 033	9 522	19 218	10 241	19 783	10 568
45-49	14 376	7 851	14 993	8 191	15 303	8 364	15 559	8 459	15 696	8 457
50-54	11 506	6 472	12 068	6 713	12 685	6 971	13 457	7 432	13 525	7 466
55-59	9 992	5 807	10 215	5 961	10 362	6 068	10 505	6 118	10 931	6 337
60-64	7 587	4 611	8 224	4 983	8 661	5 254	9 113	5 511	8 950	5 406
65-69	4 818	3 090	5 289	3 408	5 799	3 706	6 405	4 062	6 813	4 304
70+	7 003	4 514	7 569	4 894	8 155	5 315	8 657	5 703	9 095	6 018

Төрөх үеийн хүйсийн харьцаа нь 2025 онд 0 настай хүүхэд нь 111.0 байсан ба энэ нь 100 эмэгтэй хүүхэд тутамд 111 эрэгтэй хүүхэд төрж байгааг илтгэж байна. Төрөх үеийн хүйсийн харьцаа 0-17 насанд эрэгтэйчүүд ихэнхдээ давамгайлж төрсөн байдаг ч гэсэн нас ахих тусам хүйсийн харьцаа эсрэгээр болж буурдаг байна. Энэ нь эрэгтэйчүүдийн эрт нас баралттай

буюу дундаж наслалт багатай холбоотой юм. Баянгол дүүргийн хүн амын нас хүйсийн харьцаа буюу 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо 2025 онд 89.8 болжээ. 2025 оны дүүргийн нийт хүн амын 32.0 хувь нь 15 хүртэлх насны хүүхэд, 61.8 хувь нь 15-64 насны хүмүүс, 6.2 хувь нь 65, түүнээс дээш насны өндөр настан байна

ХҮСНЭГТ 8.

ХҮН АМЫН ТОО, насны бүлэг, хүйсээр, 2025 оны жилийн эцэст

Нас, насны бүлэг	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа					
ДҮН	254 710	120 522	134 188	89.8					
0	3 817	2 008	1 809	111.0	53	2 584	1 145	1 439	79.6
1	4 004	2 104	1 900	110.7	54	2 352	1 040	1 312	79.3
2	4 425	2 248	2 177	103.3	55	2 432	1 073	1 359	79.0
3	4 631	2 386	2 245	106.3	56	2 203	972	1 231	79.0
4	5 200	2 591	2 609	99.3	57	2 136	880	1 256	70.1
5	5 583	2 884	2 699	106.9	58	2 088	849	1 239	68.5
6	6 026	3 072	2 954	104.0	59	2 072	820	1 252	65.5
7	5 897	3 033	2 864	105.9	60	1 789	751	1 038	72.4
8	5 647	2 930	2 717	107.8	61	1 982	793	1 189	66.7
9	6 153	3 104	3 049	101.8	62	1 882	744	1 138	65.4
10	6 337	3 244	3 093	104.9	63	1 829	703	1 126	62.4
11	6 560	3 306	3 254	101.6	64	1 468	553	915	60.4
12	6 081	3 197	2 884	110.9	65	1 633	621	1 012	61.4
13	5 958	2 973	2 985	99.6	66	1 479	548	931	58.9
14	5 167	2 634	2 533	104.0	67	1 368	513	855	60.0
15	4 674	2 385	2 289	104.2	68	1 222	430	792	54.3
16	4 831	2 437	2 394	101.8	69	1 111	397	714	55.6
17	4 255	2 117	2 138	99.0	70	979	329	650	50.6
18	3 328	1 634	1 694	96.5	71	825	264	561	47.1
19	2 331	1 194	1 137	105.0	72	775	267	508	52.6
20	2 159	1 066	1 093	97.5	73	753	268	485	55.3
21	2 126	1 063	1 063	100.0	74	555	173	382	45.3
22	2 328	1 140	1 188	96.0	75	756	263	493	53.3
23	2 237	1 083	1 154	93.8	76	523	172	351	49.0
24	2 436	1 171	1 265	92.6	77	560	180	380	47.4
25	2 677	1 267	1 410	89.9	78	449	160	289	55.4
26	2 818	1 360	1 458	93.3	79	427	158	269	58.7
27	2 800	1 320	1 480	89.2	80	326	110	216	50.9
28	2 829	1 332	1 497	89.0	81	322	104	218	47.7
29	3 109	1 427	1 682	84.8	82	296	102	194	52.6
30	3 343	1 605	1 738	92.3	83	322	119	203	58.6
31	3 352	1 540	1 812	85.0	84	219	82	137	59.9
32	3 262	1 512	1 750	86.4	85	235	88	147	59.9
33	4 177	1 943	2 234	87.0	86	140	55	85	64.7
34	4 539	2 113	2 426	87.1	87	152	55	97	56.7
35	5 048	2 397	2 651	90.4	88	97	32	65	49.2
36	5 253	2 544	2 709	93.9	89	83	23	60	38.3
37	4 939	2 313	2 626	88.1	90	51	9	42	21.4
38	4 781	2 296	2 485	92.4	91	51	14	37	37.8
39	4 799	2 312	2 487	93.0	92	56	14	42	33.3
40	4 583	2 084	2 499	83.4	93	41	9	32	28.1
41	4 199	1 967	2 232	88.1	94	30	7	23	30.4
42	3 842	1 805	2 037	88.6	95	30	8	22	36.4
43	3 590	1 687	1 903	88.6	96	12	3	9	33.3
44	3 569	1 672	1 897	88.1	97	12	3	9	33.3
45	3 427	1 620	1 807	89.7	98	5	2	3	66.7
46	3 168	1 503	1 665	90.3	99	3	2	1	200.0
47	3 159	1 435	1 724	83.2	100+	10	2	8	25.0
48	3 036	1 368	1 668	82.0					
49	2 906	1 313	1 593	82.4					
50	2 846	1 267	1 579	80.2					
51	2 955	1 322	1 633	81.0					
52	2 788	1 285	1 503	85.5					

Хүн ам зүйн ачаалал нь хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох тэжээлгэгчийн тоо (15-аас доош, 65 ба түүнээс дээш насны хүн амын тоо) буюу хөдөлмөрийн бус насны хүн амын нийгэмд үзүүлж буй ачааллыг хүн амын насны бүлгийн бүтцээр илэрхийлнэ. 2025 оны жилийн эцсийн


байдлаар хүн ам зүйн ачаалал 61.9 болж өмнөх оноос 0.6 нэгж хувиар өсч, 2019 оноос 2.1 нэгж хувиар өссөн байна. Өөрөөр хэлбэл хөдөлмөрийн насны 100 хүн бүр 62 хүнийг тэжээж байна.

ХҮСНЭГТ 9. ХҮН АМ ЗҮЙН АЧААЛАЛ, жил бүрийн эцэст

Үзүүлэлт	2019	2020	2021	2022	2023	2024	2025
	Тоо						
0-14 насны хүн ам	73 949	77 137	79 044	82 166	83 630	83 781	81 486
65 ба түүнээс дээш насны хүн ам	10 566	11 219	11 821	12 858	13 954	15 062	15 908
15-64 насны хүн ам	141 325	143 823	145 780	152 524	156 057	161 230	157 316
Хүн ам зүйн ачаалал	59.8	61.4	62.6	62.3	62.5	61.3	61.9

2025 оны жилийн эцсийн байдлаар Баянгол дүүрэгт 60-аас дээш насны 24858 өндөр настан оршин сууж байгаагийн 9130 (36.7%) нь эрэгтэй, 15728 (63.3%) нь эмэгтэйчүүд эзэлж байна.

ЗУРАГ 5. ХҮН АМ ЗҮЙН АЧААЛАЛ, улс, дүүргээр, жил бүрийн эцэст



2019 оноос эхлэн дүүргийн хүн ам зүйн ачаалал нь улсын хүн ам зүйн ачаалалаас 0.9-5.1 нэгж хувиар илүү болсон байна.



ХОЁР. ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨН

Баянгол дүүргийн төрөлт өмнөх оны мөн үеэс 6.9 хувиар буурсан байна.

Төрөлт: Энэ онд дүүргийн хэмжээнд 3565 эх амаржиж, 3614 хүүхэд шинээр мэндэлсэн ба үүнээс 1929 (53.4%) нь хүү, 1685 (46.6%) нь охин хүүхэд байна. Төрөлт нь өмнөх оны мөн үеэс 268 (6.9%) хүүхдээр буурсан байна.

1990 оноос хойших хүн амын төрөлтийн тооны бууралтад нийгэм эдийн засгийн шилжилтийн

байдал, эмэгтэйчүүд жирэмслэлтээс сэргийлэх орчин үеийн арга хэрэгслийг хэрэглэж төрөлтөө зохицуулах болсон, гэрлэлтийн нас хойшилсон, цөөн ам бүлтэй байх сонирхолтой болсон, эмэгтэйчүүдийн боловсролын түвшин дээшилсэн зэрэг олон хүчин зүйл нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 10.


ТӨРӨЛТ, НАС БАРАЛТЫН ТОО, төрөлт, нас баралтын ерөнхий коэффициент, жил бүрийн эцэст

Үзүүлэлт	2019	2020	2021	2022	2023	2024	2025	2025 2024
	тоо							хувь
Төрөлтийн тоо	5 656	5 376	5 149	4 433	4 384	3 882	3 614	-6.9
Төрөлтийн ерөнхий коэффициент	25.0	23.5	22.0	18.3	17.5	15.1	14.0	-7.3
Нас барсан хүний тоо	1 391	989	1 269	1 410	1 342	1 354	1 370	1.2
Нас баралтын ерөнхий коэффициент	6.1	4.3	5.4	5.8	5.4	5.3	5.3	0.0 ⁺

2025 онд төрөлтийн ерөнхий коэффициент 14.0 байгаа нь 1000 хүн тутамд 14 хүүхэд шинээр төрж байгааг харуулж байна. Мөн нас баралтын ерөнхий коэффициент 5.3 байгаа нь 1000 хүн тутамд 5 хүн нас барж байгааг илтгэж байна.

ЗУРАГ 6.

ТӨРСӨН ХҮҮХДИЙН ТОО, эхийн насны бүлгээр, 2025 оны жилийн эцэст



Нийт төрсөн хүүхдийн тоог эхийн насны бүлгээр нь харвал 51 (1.4%) нь 15-19 насныхан, 428 (11.8%) нь 20-24 насныхан, 818 (22.6%) нь 25-29 насныхан, 1059 (29.3%) нь 30-34 насныхан, 979 (27.1%) нь 35-39 насныхан, 266 (7.4%) нь 40-44 насныхан, 13 (0.4%) нь 45-49 насныхан тус тус эзэлж байна.

Дүүргийн хэмжээнд 2025 онд нийт 3565 эх амаржиж, өнгөрсөн оноос 268 (7.0%) эхээр буурсан байна.

Нийт 3565 амаржсан эхийг боловсролын түвшнээр нь авч үзвэл дээд боловсролтой 2654 (74.4%) хүн, техник болон тусгай мэргэжлийн 51 (1.4%) хүн, бүрэн дунд 827 (23.2%) хүн, суурь 9 (0.3%) хүн, бага 3 (0.1%) хүн, боловсролгүй 21 (0.6%) хүн тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 11. АМАРЖСАН ЭХИЙН ТОО, боловсролын түвшнээр, жил бүрийн эцэст

Үзүүлэлт	2019	2020	2021	2022	2023	2024	2025	2025 2024
	тоо							хувь
Амаржсан эхийн тоо бүгд	5 582	5 292	5 090	4 381	4 318	3 833	3 565	-7.0
Боловсролгүй	43	46	24	31	41	25	21	-16.0
Бага	6	10	3	9	4	11	3	72.7
Бүрэн бус дунд	23	28	28	25	21	27	9	-66.7
Бүрэн дунд	1 101	1 099	1 011	912	970	883	827	-6.3
ТМС/МСҮТ	76	70	54	64	52	52	51	-1.9
Дээд	4 333	4 039	3 970	3 340	3 230	2 835	2 654	-6.4

¹-дахин

Нас баралт: Дүүргийн хэмжээнд 2025 онд 1370 хүн нас барсан бөгөөд өмнөх оноос 12 (1.2%) хүнээр өссөн сөрөг үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ 12. НАС БАРСАН ХҮНИЙ ТОО, насны бүлгээр, жил бүрийн эцэст

Насны бүлэг	2020	2021	2022	2023	2024	2025	2025 2024
	тоо						хувь
Бүгд	989	1 269	1 410	1 342	1 354	1 370	1.2
0-4	54	66	323	327	288	284	-1.4
5-9	5	3	11	4	4	6	50.0
10-14	2	4	5	6	8	7	-12.5
15-19	4	6	3	11	8	10	25.0
20-24	9	12	9	13	7	15	114.3
25-29	9	15	13	15	14	13	-7.1
30-34	22	31	36	34	26	36	38.5
35-39	39	36	35	41	54	43	-20.4
40-44	63	55	65	47	58	74	27.6
45-49	67	101	97	56	95	67	-29.5
50-54	81	91	93	99	78	109	39.7
55-59	106	109	119	110	98	98	0.0 ⁼
60-64	96	132	124	121	132	132	0.0 ⁼
65-69	93	116	112	106	105	117	11.4
70+	339	492	365	352	379	359	-5.3

¹-дахин


Нийт нас барсан хүний 20.7 хувь нь 0-4 насны, 1.7 хувь нь 5-19 насны, 2.0 хувь нь 20-29 насны, 5.8 хувь нь 30-39 насны, 10.3 хувь нь 40-49 насны, 15.1 хувь нь 50-59 насны, 9.6 хувь нь 60-64 насны, 8.5 хувь нь 65-69 насны, 26.3 хувь нь 70-аас дээш насны иргэд эзэлж байна.



10 нас баралт тутмын 6 эрэгтэй, 4 эмэгтэй хүн байна.


Энэ нь эмэгтэйчүүдтэй харьцуулахад эрэгтэйчүүдийн нас баралтын түвшин өндөр байгааг илтгэж байна.

ЗУРАГ 7. НАС БАРСАН ХҮНИЙ ТОО, хүйсээр, жил бүрийн эцэст



Хүн амын гэрлэлт, цуцлалт: 2025 оны жилийн эцсийн байдлаар дүүргийн хэмжээнд нийт 1023 хос гэрлэлтээ шинээр батлуулсан нь өмнөх оноос 145 (12.4%) хүнээр буурсан бол 435 хос гэрлэлтээ дуусгавар болгосон нь өмнөх оноос 27 (6.6%) аар өссөн байна.

ЗУРАГ 8. ГЭРЛЭЛТ, ГЭР БҮЛ ЦУЦЛАЛТЫН ТОО, жил бүрийн эцэст



Гэрлэлтийн ерөнхий коэффициентоос харахад 1000 хүн тутмын 4 нь, гэрлэлтийн тусгай коэффициентоос харахад 15 ба түүнээс дээш насны 1000 хүн тутмын ойролцоогоор 6 нь шинээр гэр бүл болж байна.

Харин салалтын ерөнхий коэффициентоос харахад нь 1000 хүн тутмын 2 нь, тусгай коэффициент нь 15 ба түүнээс дээш насны 1000 хүн тутмын 2 нь гэр бүлээ дуусгавар болгосон байна.

ХҮСНЭГТ 13.

ГЭРЛЭЛТ, ЦУЦЛАЛТЫН ТОО, ерөнхий, тусгай коэффициент, жил бүрийн эцэст


Он	Гэрлэлтийн тоо	Гэрлэлтийн ерөнхий коэффициент	Гэрлэлтийн тусгай коэффициент	Салалтын тоо	Салалтын ерөнхий коэффициент	Салалтын тусгай коэффициент
2018	1 810	8.1	11.7	433	1.9	2.8
2019	1 896	8.4	12.5	502	2.2	3.3
2020	978	4.3	6.3	258	1.1	1.7
2021	1 124	4.8	7.1	357	1.5	2.3
2022	1 607	6.6	10.3	463	1.9	3.0
2023	1 522	6.1	10.0	450	1.8	2.7
2024	1 168	4.5	6.7	408	1.6	2.3
2025	1 023	4.0	5.9	435	1.7	2.5

Монгол Улсын Засгийн газраас 2008 оноос шинээр гэр бүлээ батлуулсан иргэдэд 500 мянган төгрөгийн тэтгэмжийг 2011 он хүртэл олгосон байдаг. Мөнгөн тэтгэмжтэй холбоотойгоор 2006 оноос гэрлэлтийн тоо эрс

өссөн ба мөн дагаад цуцлалтын тоо 2012 оныг хүртэл тасралтгүй нэмэгджээ. Мөн манай дүүргийн хувьд сүүлийн 1 жил гэрлэлт буурч, цуцлалт өсөх хандлагатай байна.

ЗУРАГ 9.

ГЭРЛЭЛТЭЭ БҮРТГҮҮЛСЭН ХҮНИЙ ТОО, насны бүлгээр, 2025 оны жилийн эцэст



Гэрлэлтээ бүртгүүлсэн хүний тоог насны бүлэг болон хүйсээр авч үзвэл нийт гэрлэлтээ бүртгүүлсэн эрэгтэйчүүдийн 75.6 хувь, эмэгтэйчүүдийн 79.4 хувь нь 20-39 насныхан байна.



ГУРАВ. НИЙГМИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ


Баянгол дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 1.2 хувиар буурсан байна.

Үрчлэгдсэн хүүхэд: Үрчлэлт гэж үрчлэн авагч нь хүүхэд үрчлэн авсан тухайгаа иргэний гэр бүлийн асуудал эрхэлсэн тухайн шатны албанд бүртгүүлж, гэрчилгээ авсан тохиолдлыг ойлгоно. Гэр бүлийн тухай хуулийн 57.1-д “үрчлэгч нь насанд хүрсэн, иргэний эрх зүйн

эрхийн бүрэн чадамжтай, хүүхдийг тэжээн тэтгэж, өсгөн хүмүүжүүлэх зохих боломжтой хүн байна” гэж заажээ. Үрчлүүлэх хүүхдийн судалгаа гаргаж, бүртгэл хөтлөх үүргийг Гэр бүлийн тухай хуульд сум, дүүргийн Засаг даргад оноосон байдаг.

ЗУРАГ 10.

ҮРЧЛЭГДСЭН ХҮҮХЭД, НИЙСЛЭЛ, ДҮҮРЭГ, ЖИЛ БҮРИЙН ЭЦЭСТ




Нийслэлийн хэмжээнд 2025 онд 461 хүүхэд үрчлэгдсэнээс 53 (11.5%) хүүхэд тус дүүрэгт үрчлэгдсэн байна. Өнгөрсөн онтой харьцуулахад 32 (37.6%) хүүхдээр буурчээ.

Хагас, бүтэн өнчин хүүхэд: 2025 онд нийт өнчин хүүхдийн тоо 3541 байгаа ба 129 (3.6%) хүүхэд бүтэн өнчин, 3412 (96.4%) хүүхэд хагас өнчин байна. Бүтэн өнчин хүүхэд өмнөх оноос 1 (0.8%) хүүхдээр өссөн бол хагас өнчин хүүхэд өмнөх оноос 78 (2.3%) хүүхдээр өссөн байна.

ЗУРАГ 11.


ХАГАС, БҮТЭН ӨНЧИН ХҮҮХДИЙН ТОО, ЖИЛ БҮРИЙН ЭЦЭСТ



Хагас, бүтэн өнчин хүүхдүүдийг хороогоор харвал хамгийн их нь 26 дугаар хороо, хамгийн бага нь 5, 14, 15, 20, 30 дугаар хороод байна.

ХҮСНЭГТ 14.**ХАГАС, БҮТЭН ӨНЧИН ХҮҮХДИЙН ТОО, хороогоор, жил бүрийн эцэст**

Хороо	Бүтэн өнчин хүүхэд					Хагас өнчин хүүхэд				
	2021	2022	2023	2024	2025	2021	2022	2023	2024	2025
	тоо					тоо				
Дүүргийн дүн	114	126	111	130	129	1 267	1 461	2 602	3 334	3 412
I хороо	4	3	4	3	5	88	93	103	101	93
II хороо	7	4	1	4	5	32	30	96	128	123
III хороо	9	2	-	1	2	39	34	96	171	153
IV хороо	8	6	4	6	4	50	32	158	142	125
V хороо	1	1	2	3	6	32	18	35	47	47
VI хороо	5	2	3	3	1	99	42	70	74	70
VII хороо	2	7	10	9	4	75	49	72	126	109
VIII хороо	3	3	3	4	5	42	50	86	114	126
IX хороо	9	9	6	4	6	30	30	86	122	115
X хороо	5	5	3	2	7	37	37	54	77	105
XI хороо	3	4	4	4	3	76	59	98	107	103
XII хороо	3	2	2	3	3	36	58	68	69	69
XIII хороо	2	2	2	1	3	33	33	48	58	62
XIV хороо	2	2	3	3	4	20	19	22	45	46
XV хороо	4	3	4	3	2	29	32	41	48	44
XVI хороо	6	3	3	2	4	75	46	33	53	49
XVII хороо	2	1	-	3	10	55	65	72	58	54
XVIII хороо	1	4	6	9	4	34	22	42	107	107
XIX хороо	4	3	4	7	7	16	29	47	66	60
XX хороо	5	5	3	3	3	18	15	38	31	29
XXI хороо	12	11	6	5	5	138	118	148	199	185
XXII хороо	2	5	4	6	4	49	78	79	134	137
XXIII хороо	7	4	4	8	6	94	103	81	101	95
XXIV хороо	4	5	5	6	8	52	54	147	183	210
XXV хороо	4	6	6	6	4	18	17	56	60	62
XXVI хороо	-	7	5	4	3	-	64	194	275	310
XXVII хороо	-	8	9	8	6	-	14	62	120	118
XXVIII хороо	-	1	-	1	1	-	37	63	54	56
XXIX хороо	-	-	-	-	2	-	12	32	76	79
XXX хороо	-	2	1	2	1	-	36	28	34	50
XXXI хороо	-	1	1	2	1	-	69	98	90	77
XXXII хороо	-	-	-	1	1	-	21	79	69	86
XXXIII хороо	-	1	1	2	2	-	10	104	135	147
XXXIV хороо	-	4	2	2	4	-	35	66	60	111

ЗУРАГ 12. ӨНЧИН ХҮҮХДИЙН ТОО, хороогоор, хүйсээр, 2025 оны жилийн эцэст

Нийт хагас өнчин хүүхдүүдийг насны бүлгээр нь авч үзвэл 280 (8.2%) нь 0-4 насны, 927 (27.2%) нь 5-9 насны, 1441 (42.2%) нь 10-14 насны, 764 (22.4%) хувь нь 15-17 насны хүүхдүүд байна.

Харин бүтэн өнчин хүүхдүүдийн 3.1 хувь нь 0-4 насны, 17.8 хувь нь 5-9 насны, 41.1 хувь нь 10-14 насны, 38.0 хувь нь 15-17 насны хүүхэд эзэлж байна.

ХҮСНЭГТ 15. ХАГАС, БҮТЭН ӨНЧИН ХҮҮХДИЙН ТОО, насны ангиллаар, жил бүрийн эцэст

Насны ангилал	Бүтэн өнчин хүүхэд						Хагас өнчин хүүхэд					
	2021	2022	2023	2024	2025	2025 2024	2021	2022	2023	2024	2025	2025 2024
	тоо					хувь	тоо					хувь
Бүгд	114	126	111	130	129	-0.8	2 602	1 461	2 602	3 334	3 412	2.3
0-4	-	7	3	3	4	33.3	276	148	276	345	280	-18.8
5-9	13	25	21	26	23	-11.5	785	433	785	956	927	-3.0
10-14	44	39	47	48	53	10.4	987	565	987	1 316	1 441	9.4
15-17	57	55	40	53	49	-7.5	554	315	554	717	764	6.6

Өрх толгойлсон эцэг, эх: 2025 оны байдлаар нийт өрх толгойлсон эцэг, эхчүүдийн тоо 2084 болж өмнөх оноос 179 (9.4%) хүнээр буурсан үзүүлэлттэй байна. Үүнээс өрх толгойлсон эх


1805 (86.6%) болж өмнөх оноос 140 (8.4%) хүнээр, өрх толгойлсон эцэг 240 (13.4%) болж 39 (16.3%) хүнээр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

ЗУРАГ 13. ӨРХ ТОЛГОЙЛСОН ХҮНИЙ ТОО, хүйсээр, жил бүрийн эцэст

Өрх толгойлсон эцэг, эхийн тоог ам бүлийн тоогоор авч үзвэл 3 хүртэл ам бүлтэй 556 (26.8%) хүн, 3-5 ам бүлтэй 1356 (65.3%) хүн, 6 ба түүнээс дээш ам бүлтэй 163 (7.9%) өрх байна.

ЗУРАГ 14.

ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭЦЭГ, ЭХИЙН ТОО, хороогоор, жил бүрийн эцэст



2022 онд тус дүүргийн хороодын хилийн цэсэд өөрчлөлт орж шинээр 9 хороо байгуулагдсантай холбоотойгоор өрх толгойлсон эцэг, эхийн тоонд өөрчлөлт орсон. Өрх толгойлсон эцэг, эхийг хороогоор нь авч үзвэл, өрх толгойлсон эхийн тоо хамгийн өндөр нь 26 дугаар хороонд

182 байгаа бол хамгийн бага нь 5, 20 дугаар хороодод бүртгэгджээ. Харин өрх толгойлсон эцгийн тоо хамгийн их буюу 17 нь 22 дугаар хороо, 19 нь 24 дүгээр хороодод бүртгэгдсэн бол хамгийн бага нь 30 дугаар хороонд 1 өрх толгойлсон эцэг бүртгэгдсэн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн ам: 2025 оны жилийн эцсийн байдлаар тус дүүрэгт 5611 хөгжлийн бэрхшээлтэй хүн амьдарч байгаа нь өмнөх оны мөн үеэс 188 (3.2%) хүнээр буурсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний 2519 (43.9%) эмэгтэйчүүд, 909 (15.9%) хөдөлмөр эрхэлдэг, 847 (14.8%) хувь нь 0-18 насны хүүхдүүд байна.

Нийт хөгжлийн бэрхшээлтэй хүний тоог өвчний төрлөөр авч үзвэл 506 (8.9%) хүн харааны, 182 (3.2%) хүн хэл ярианы, 433 (7.6%) хүн сонсголын, 703 (12.4%) хүн хөдөлгөөний, 1082 (19.1%) хүн сэтгэцийн, 595 (10.5%) хүн хавсарсан, 2160 (38.3%) хүн бусад хөгжлийн бэрхшээлтэй иргэд тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 16.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТОО, өвчний төрөл, хэлбэрээр, жилийн эцэст

Үзүүлэлт	2021	2022	2023	2024	2025	2025 2024
	тоо					хувь
Бүгд	5 831	6 245	5 921	5 733	5 661	-1.2
Өвчний төрлөөр						
Төрөлхийн	2 099	1 958	2 031	2 086	2 031	-2.6
Олдмол	3 732	4 287	3 890	3 647	3 890	6.7
Хэлбэрээр						
Хараа	482	599	532	507	506	-0.2
Яриа	188	163	93	131	182	38.9


Сонсгол	526	505	464	449	433	-3.6
Хөдөлгөөн	837	775	696	740	703	-5.0
Сэтгэц	946	981	1 027	1 079	1 082	0.3
Хавсарсан	661	543	348	476	595	25.0
Бусад	2 191	2 679	2 761	2 351	2 160	-8.1

Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хэлбэрээс нь харвал өнгөрсөн оноос ярианы бэрхшээлтэй хүн 38.9 хувиар, сэтгэцийн бэрхшээлтэй хүн 0.3 хувиар, хавсарсан бэрхшээлтэй хүн 25.0 хувиар тус тус өссөн бол харааны бэрхшээлтэй хүн 0.2

хувиар, сонсголын бэрхшээлтэй хүн 3.6 хувиар, хөдөлгөөний бэрхшээлтэй хүн 5.0 хувиар, бусад хөгжлийн бэрхшээлтэй хүн 8.1 хувиар тус тус буурсан байна.

ЗУРАГ 15.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭД, шалтгаанаар, дүнд эзлэх хувиар, 2025 оны жилийн эцэст



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 37.3 хувь нь төрөлхийн, үлдсэн 54.3 хувь нь өвчнөөр болон осол гэмтлийн улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон байна.

Нийт олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүний тоог төрлөөр авч үзвэл 3074 (86.5%) хүн ердийн өвчнөөр, 198 (5.6%) хүн мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр, 84 (2.4%) хүн зам тээврийн ослоор, 74 (2.1%) хүн үйлдвэрийн ослоор, 120 (3.4%) хүн ахуйн ослоор хөгжлийн бэрхшээлтэй болсон байна.

ХҮСНЭГТ 17.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТОО, хороогоор, жил бүрийн эцэст

Хороо	2022		2023		2024		2025	
	Бүгд	0-17 насны хүүхэд	Бүгд	0-17 насны хүүхэд	Бүгд	0-17 насны хүүхэд	Бүгд	0-17 насны хүүхэд
		тоо		тоо		тоо		тоо
Дүүргийн дүн	6 245	811	5 921	955	5 733	962	5 661	1 141
I хороо	287	42	249	39	191	38	228	36
II хороо	231	32	228	34	218	39	227	35
III хороо	180	6	193	8	164	13	202	12
IV хороо	236	25	268	31	215	29	202	25
V хороо	172	27	166	36	148	29	164	39
VI хороо	245	40	209	30	183	42	218	96

VII хороо	141	24	157	23	97	25	138	25
VIII хороо	281	41	204	29	191	33	178	34
IX хороо	142	28	103	26	218	25	98	35
X хороо	295	28	255	42	184	32	213	49
XI хороо	153	19	155	29	121	30	141	22
XII хороо	114	8	107	13	94	14	103	17
XIII хороо	203	18	140	17	138	15	79	17
XIV хороо	144	21	157	27	112	19	128	23
XV хороо	115	21	123	18	101	16	103	23
XVI хороо	213	13	115	9	124	10	124	10
XVII хороо	238	41	189	35	217	42	193	44
XVIII хороо	159	4	325	51	310	50	390	69
XIX хороо	167	28	135	25	197	20	248	43
XX хороо	92	7	74	-	56	1	58	11
XXI хороо	320	27	266	21	242	20	281	27
XXII хороо	333	35	239	32	227	36	195	43
XXIII хороо	227	18	229	20	200	17	147	17
XXIV хороо	125	33	149	42	151	44	181	64
XXV хороо	153	27	178	27	181	30	142	26
XXVI хороо	274	57	295	73	287	64	271	63
XXVII хороо	165	27	94	35	115	35	113	34
XXVIII хороо	114	15	121	32	112	34	124	34
XXIX хороо	90	12	130	29	127	29	123	27
XXX хороо	120	11	132	31	163	36	148	32
XXXI хороо	117	20	104	19	74	13	100	25
XXXII хороо	204	24	217	31	217	31	182	27
XXXIII хороо	79	8	115	24	116	27	114	34
XXXIV хороо	116	24	100	17	116	24	105	23

Нийт хөгжлийн бэрхшээлтэй хүний 20.2 хувийг 0-17 насны хүүхдүүд эзэлж байгаа бол 6,17,18, 24, 26 дугаар хороодод хамгийн их буюу 40-с дээш хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд байнга оршин сууж байна.

Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 2277 (39.3%) хүн байнгын асаргаанд байна. Энэ нь

өнгөрсөн жилээс 518 (23.3%) хүнээр өссөн байна. Нийгмийн халамжийн тэтгэвэр тогтоолгосон хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо 3517 байна.

Тус дүүрэгт сургуульд сурдаггүй хөгжлийн бэрхшээлтэй 126 хүүхэд байгаа ба өмнөх оны мөн үеэс 41 (48.2%) хүүхдээр өссөн байна.

Нийгмийн зарим үзүүлэлт:

2024 оны жилийн эцсийн байдлаар нийт өрхийн 1247 (1.7%) нь ганц биеэрээ амьдарч буй ахмад настан байгаагаас 240 (19.2%) нь 60-аас дээш насны эрэгтэй, 1007 (80.8%) нь 55-аас дээш насны эмэгтэй байна.

ХҮСНЭГТ 18.

Ганц бие ахмад настай өрхийн тоо, жил бүрийн эцэст

Үзүүлэлт	2019	2020	2021	2022	2023	2024	2025	2025 2024
	тоо							хувь
Ганц бие ахмад настай өрхийн тоо, бүгд	485	625	844	1 011	1 339	1 247	1 456	16.8

Дүүргийн хэмжээнд ихэр хүүхэдтэй 665 өрхөд 1350 хүүхэд байгаа ба 2 ихэр хүүхэдтэй 659 (99.1%) өрх, 3 ихэр хүүхэдтэй 6 (0.9%) өрх байна. Өнгөрсөн жилээс ихэр хүүхдийн тоо 169 (11.1%) хүүхдээр буурсан үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ 19.**ИХЭР ХҮҮХДИЙН ТОО, хүүхдийн тоогоор, жил бүрийн эцэст**

Үзүүлэлт	2019	2020	2021	2022	2023	2024	2025	2025 2024
	тоо							хувь
Ихэр хүүхэдтэй өрх	673	688	710	803	843	690	665	-3.6
Хоёр ихэр хүүхэдтэй	665	679	702	794	834	678	659	-2.8
Гурван ихэр хүүхэдтэй	8	9	8	9	9	12	6	-50.0
Ихэр хүүхдийн тоо	1 356	1 394	1 428	1 621	1 709	1 519	1 350	-11.1
Хоёр ихэр хүүхэд	1 332	1 367	1404	1 594	1 682	1 480	1 332	-10.0
Гурван ихэр хүүхэд	24	27	24	27	27	39	18	-53.8

ДӨРӨВ. АРГА, АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

Хүн ам зүйн статистикийн үндсэн үзүүлэлтүүдэд хүн амын тоо, түүний хүйс, насны бүтэц, төрөлт, нас баралт, гэрлэлт, гэр бүл салалт, тухайн улс оронд шилжин ирэгчид, шилжин явагчид болон дотоодын шилжих хөдөлгөөний талаарх статистик үзүүлэлтүүдийг хамруулна.

Ойлголт, тодорхойлолт:

Хүн амын тоо: Тодорхой хугацаанд, тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын тоог илэрхийлнэ. Хүн амын тоог бэлэн болон суурин хүн амаар тооцдог.

Суурин хүн ам: Тухайн засаг захиргааны нэгжид 180 хоног буюу 6 сараас дээш хугацаагаар оршин сууж байгаа хүн амыг хэлнэ.

Жилийн эхний хүн ам: Тайлант оны эхэнд, тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын тоог илэрхийлнэ.

Байнга оршин суугч: Монгол Улсад 180 хоногоос дээш хугацаагаар оршин суугаа болон 180 хоногоос доош хугацаагаар сууж байгаа ч цаашид 180 хоногоос дээш хугацаагаар оршин суух нь тодорхой хүнийг хамруулна

Жилийн эцсийн хүн ам: Тайлант оны эцэст, тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын тоог илэрхийлнэ.

Хүн амын жилийн дундаж тоо: Тайлант оны эхний болон эцсийн хүн амын тооны дунджаар илэрхийлэгдэнэ.

$$XX = \frac{XA_{(эр)}}{XA_{(эм)}} * 100$$

Хүн амын өсөлт, бууралт: Тодорхой хугацааны туршид хүн амын тооны эерэг өөрчлөлтийг хүн амын өсөлт, сөрөг өөрчлөлтийг хүн амын бууралт гэнэ.

Хүн амын ердийн цэвэр өсөлт, бууралт: Тухайн жилийн хүн амын төрөлт, нас баралтын тооны зөрүүгээр илэрхийлэгдэнэ.

$$EC\theta(XA) = TT - НБТ$$

Нас: Төрсөн өдрөөс эхлэн (он, сар, өдөр) бүтэн жилүүдээр тооцсон хугацаа буюу төрсөн сар, жилийн асуултын хариултад суурилсан

тооцоогоор илэрхийлсэн хугацааг нас гэнэ.

Дундаж наслалт: Шинээр төрсөн (төрөх үеийн) хүүхдийн цаашид үргэлжлэн амьдрах дундаж хугацааг (жил) хэлнэ.

Хүн амын нас, хүйсийн бүтэц: Насны бүлэг тус бүр дэх эрэгтэй, эмэгтэй хүн амын тоог хувийн жингээр илэрхийлнэ.

Хүн амын нас, хүйсийн суварга: Хүн амыг нас, хүйсээр хуваарилан харуулдаг босоо байрлалтай диаграмм юм. Онолын хувьд босоо тэнхлэгт нийт хүн амд тухайн насны хүн амын эзлэх хувийн жингээр харуулах ба бага насныхныг суваргын доод хэсэгт, хэвтээ тэнхлэгийн зүүн талд эрэгтэйчүүдийг, баруун талд эмэгтэйчүүдийг тус тус дүрслэн харуулдаг. Хүн амын нас, хүйсийн суварга нь цаг хугацааны тодорхой үеийн хүн амын нөхөн үржихүйн тасралтгүй процессын явцыг харуулна. Хэрэв хүн амын нөхөн үржихүйн процессын тухайлбал төрөлт, нас баралтын түвшинд ямар нэг нөлөө гараагүй тохиолдолд насны пирамид нь тэнцүүхэн дүрслэгдэх ба урт хугацааны туршид төрөлтийн өндөр түвшин хадгалагдаж, нас баралтын түвшин ч харьцангуй өндөр байсан тохиолдолд суваргын суурь нь өргөн, орой руугаа нарийссан хэлбэртэй, харин төрөлт, нас баралтын түвшин бага байсан тохиолдолд суваргын суурь нь нарийхан, орой руугаа өргөссөн хэлбэртэй байна.²

Хүйсийн харьцаа: Эрэгтэйчүүдийн тоог эмэгтэйчүүдийн тоонд харьцуулсан харьцаа бөгөөд энэ нь 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоог илэрхийлнэ.

XX - Хүйсийн харьцаа

XA_(эр) - Эрэгтэй хүн амын нийт тоо

XA_(эм) - Эмэгтэй хүн амын нийт тоо

Хүн ам зүйн ачаалал: Хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох тэжээгдэгчийн тоо (15-аас доош, 65 ба түүнээс дээш насны хүн амын тоо) буюу хөдөлмөрийн бус насны хүн амын нийгэмд үзүүлж буй ачааллыг хүн амын насны бүлгийн бүтцээр илэрхийлнэ.

Хүн амын нягтрал: Нэгж газар нутагт ногдох хүн амын тоог илэрхийлнэ. Жишээ нь нэг хавтгай дөрвөлжин км газар нутагт ногдох хүн ам эсвэл тариалах боломжтой нэг хавтгай дөрвөлжин км газар нутагт ногдох хүн ам гэх мэт.

$$XA_{(няг)} = \frac{XA_{(с)}}{НДХ}$$

$XA_{(няг)}$ - Хүн амын нягтрал
 $XA_{(с)}$ - Суурин хүн амын тоо
 $НДХ$ - Нийт нутаг дэвсгэрийн хэмжээ

Төрөлт: Эмэгтэйчүүдийн амьд төрүүлсэн хүүхдийн тоогоор хэмжигдэнэ.

Төрүүлсэн хүүхдийн тоо: Тухайн эмэгтэйн нөхөн үржихүйн амьдралынхаа хугацаанд нийт хэдэн хүүхэд төрүүлснийг харуулна. Эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн амьдралын хугацаа дуусахыг хүлээхгүйгээр нэг эмэгтэй хэдэн хүүхэд төрүүлж байгааг тооцох шаардлага гардаг. Энэ үед төрөлтийн нийлбэр коэффициент гэсэн үзүүлэлтийг ашиглаж болно.

Төрөх үеийн хүйсийн харьцаа: Тухайн жилийн амьд төрсөн 100 эмэгтэй хүүхэд тутамд ногдох амьд төрсөн эрэгтэй хүүхдийн тоог илэрхийлнэ.

Төрөлтийн ерөнхий коэффициент: Тухайн жилийн 1000 хүн тутамд ногдох амьд төрсөн хүүхдийн тоог илэрхийлнэ.

$$ТЕК = \frac{АТ}{XA_{(дн)}} * 1000$$

$ТЕК$ - Төрөлтийн ерөнхий коэффициент
 $АТ$ - Тухайн жилд амьд төрсөн нийт хүүхдийн тоо
 $XA_{(дн)}$ - Хүн амын жилийн дундаж тоо

Нас баралт: Хүн төрөлхтний дунд гарч буй нөхөн үржихүйн үзэгдлийн нэг. Хүн амын амьжиргааны түвшин, амьдралын хэв маяг, эрүүл ахуйн нөхцөл, өвчлөл нь нас баралтын түвшинд нөлөө үзүүлдэг учир энэ үзүүлэлтийг нас баралтын шалтгаанаар нь тодорхойлж болно.

Нас баралтын ерөнхий коэффициент: Тухайн жилийн 1000 хүн тутамд ногдох нас баралтын тоог илэрхийлнэ.

$$НБЕК = \frac{НБТ}{XA_{(дн)}} * 1000$$

$НБЕК$ - Нас баралтын ерөнхий коэффициент
 $НБТ$ - Тухайн жилд нас барсан нийт хүний тоо
 $XA_{(дн)}$ - Хүн амын жилийн дундаж тоо

Гэр бүл: Голдуу гэрлэлт, төрөлт эсвэл үрчлэлтээр холбогдон хамтдаа амьдарч буй хоёр ба түүнээс олон тооны хүнийг хэлнэ. Гэр бүл нь төрсөн ах, эгч, дүүс, ураг төрлийн бусад холбоотой хүмүүс, гэр бүл тэдгээрийн үр хүүхдээс бүрдэж болно.

Гэрлэлтийн байдал: Гэр бүлийн тухай Монгол Улсын хууль болон уламжлалт ёсны дагуу гэрлэлтийн байдлыг дараахь төрлүүдээр тодорхойлно.

Огт гэр бүл болоогүй: Арван тав, түүнээс дээш настай, огт гэрлэж байгаагүй хүнийг энд хамруулна.

Гэрлэсэн гэдэгт дараахь хүн амыг хамруулна.

I. Батлуулсан гэр бүлтэй: Гэрлэлтээ иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлсэн, гэрлэлтийн баталгаатай хүмүүсийг хэлнэ.

II. Батлуулаагүй гэр бүлтэй: Гэр бүл болж хамтран амьдарч байгаа боловч (хугацаа харгалзахгүйгээр) иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлж, гэр бүлээ батлуулаагүй хүмүүсийг хэлнэ.

Бэлбэсэн: Эхнэр, нөхрийн аль нэг нь нас барснаас хойших хугацааг харгалзахгүйгээр дахин гэрлээгүй бол бэлбэсэн гэж үзнэ.

Тусгаарласан: Гэр бүлээ албан ёсоор цуцлуулаагүй, тусдаа амьдарч байгаа хүмүүсийг тусгаарласан гэж үзнэ.

Цуцалсан: Гэр бүлээ хуулийн дагуу цуцалснаас хойших хугацааг

харгалзахгүйгээр дахин гэрлээгүй байгаа хүмүүсийг гэр бүлээ цуцалж салсан гэж үзнэ.

Гэрлэлтийн ерөнхий коэффициент: Тухайн жилийн 1000 хүн тутамд ногдох гэрлэлтийн тоог илэрхийлнэ.

$$\frac{ГЕК}{*1000} \quad ГТ \quad ХА(дун)$$

ГЕК – Гэрлэлтийн ерөнхий коэффициент

ГТ - Тухайн жилийн гэрлэлтийн нийт тоо

ХА(дун) - Хүн амын жилийн дундаж тоо

Гэрлэлтийн тусгай коэффициент: Тухайн жилийн 15 ба түүнээс дээш насны 1000 хүн тутамд ногдох гэрлэлтийн тоог илэрхийлнэ.

$$\frac{ГТК}{*1000} \quad ГТ \quad ХА(15+)$$

ГТК – Гэрлэлтийн тусгай коэффициент

ГТ - Тухайн жилийн гэрлэлтийн нийт тоо

ХА(15+) – 15 ба түүнээс дээш насны хүн амын тоо

Цуцлалт: Зохих шатны шүүхээр гэрлэлтээ дуусгавар болгосныг илэрхийлнэ.

Салалтын ерөнхий коэффициент: Тухайн жилийн 1000 хүн тутамд ногдох салалтын тоог илэрхийлнэ.

$$\frac{СЕК}{*1000} \quad СТ \quad ХА(дун)$$

СЕК – Салалтын ерөнхий коэффициент

СТ - Тухайн жилийн салалтын нийт тоо

ХА(дун) - Хүн амын жилийн дундаж

тоо

Салалтын тусгай коэффициент: Тухайн жилийн 15 ба түүнээс дээш насны 1000 хүн тутамд ногдох салалтын тоог илэрхийлнэ.

$$\frac{СТК}{*1000} \quad СТ \quad ХА(15+)$$

СТК – Салалтын тусгай коэффициент

СТ - Тухайн жилийн салалтын нийт тоо

ХА(15+) – 15 ба түүнээс дээш насны хүн амын тоо

Үрчлэлт: Үрчлэн авагч нь хүүхэд үрчлэн авсан тухайгаа иргэний гэр бүлийн асуудал эрхэлсэн тухайн шатны албанд бүртгүүлж, гэрчилгээ авсан тохиолдлыг ойлгоно.

Бүтэн өнчин хүүхэд: Эцэг, эх нь тогтоогдоогүй, эсвэл эцэг, эх нь хоёул нас барсан, сураггүй алга болсон, эрх зүйн чадамжгүй, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, түүнчлэн эцэг тодорхойгүйн улмаас эхтэйгээ амьдарч байгаад эх нь нас барсан, гэр бүл салсны улмаас асрамждаа авсан эх /эцэг/ нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдийг хамруулна /Монгол Улсын Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7/.

Хагас өнчин хүүхэд: Эцэг эсвэл эх нь тогтоогдоогүй, эцэг эхийн аль нэг нь нас барсан, сураггүй алга болсон, эрх зүйн чадамжгүй, эцэг эсвэл эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, гэр бүл салсны улмаас эцэг эсвэл эхийн асрамжид орсон 18 хүртэлх насны хүүхдийг хамруулна.

Өрх толгойлсон эх/эцэг: Нөхөр, эхнэрийн аль нэг нь нас барсан, эсвэл сураггүй алга болсон нь шүүхээр тогтоогдсон, гэрлэлтээ цуцлуулсан, эх /эцэг/ байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, гэрлэж байгаагүй боловч төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэдтэй ганц бие эх /эцэг/-ийг хамааруулна /Монгол Улсын Нийгмийн

халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8/. Өрх тэргүүлдэг гэсэн нөхцөл хангагдсан бүх хүнийг насны хязгаар харгалзахгүйгээр өрх толгойлсон эх /эцэг/ -д хамруулна.

Тэтгэвэр, тэтгэмж тогтоогдоогүй ахмад настай

хүн: Нийгмийн халамжийн тухай хуулийн 12.1.1-д 60, түүнээс дээш насны эрэгтэй, 55, түүнээс дээш насны эмэгтэйд тэтгэвэр авах эрх үүснэ гэж заасан байдаг. Тэгвэл энэ хуулийн 14 дүгээр зүйл зөрчигдсөн буюу тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох өргөдөлд хавсаргах холбогдох баримт бичгийн бүрдэл дутуу, өргөдөл өгснөөс хойш шийдвэрлэх хугацаанд шийдвэрлэгдээгүй хоцорсон болон бусад шалтгааны улмаас тэтгэвэр, тэтгэмж нь тогтоогдоогүй 55, түүнээс дээш насны эмэгтэй, 60, түүнээс дээш насны эрэгтэйг хамруулна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн: Бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг “хөгжлийн бэрхшээлтэй” гэж ойлгоно /Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухайн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1/.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн амд хөдөлмөр магадлах комисс, Хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хуралдаанаар орж хөдөлмөрийн чадвар алдалтын хувийг тогтоолгосон болон тус комиссоор ороогүй боловч тухайн хүн өөрийгөө хөгжлийн бэрхшээлтэй гэж тодорхойлсон хүн амыг хамруулна.

Хөгжлийн бэрхшээлийн төрлийг дараах байдлаар ойлгоно. Үүнд:

Төрөлхийн: Хөгжлийн бэрхшээлийн төрөлд удамшлын эмгэг, согог, жирэмсний болон төрөх үеийн хүндрэлээс шалтгаалан бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогтой болж бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хамруулна.

Олдмол: Хөгжлийн бэрхшээлийн төрөлд ахуйн болон үйлдвэрлэлийн осол, гэмтэл, ердийн болон мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэхүйн согогтой болж, бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хамруулна.

Хөгжлийн бэрхшээлийн илэрсэн хэлбэрийг дараах байдлаар ойлгоно. Үүнд:

Харааны: Харах эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний “харах” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан хүнийг хамруулна. Хэрэв нүдний шил зүүгээд хэвийн түвшинд хардаг бол харааны бэрхшээлд тооцохгүй.

Ярианы: Хэл, ярианы эрхтний гэмтэл, согог, өвчин, эмгэгийн улмаас хүний “ярих”, “харилцах” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан хүнийг хамруулна.

Сонсголын: Сонсголын болон хэл, ярианы эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний “сонсох” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан хүнийг хамруулна. Хэрэв сонсголын төхөөрөмж зүүгээд сонсох түвшин хэвийн түвшинд байдаг бол энд хамруулахгүй.

Хөдөлгөөний: Биеийн тодорхой хэсгийг хөдөлгөх чадваргүйн улмаас хүний амьдралын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг гүйцэтгэх чадваргүй хүнийг хамруулна.

Сэтгэцийн: Сэтгэцийн эмгэг нь бодох сэтгэх, мэдрэх ухамсарлахуйн болон зан төлвийн, оюун ухааны өөрчлөлтөөр илрэх бөгөөд үүнийхээ улмаас хүний нийгэмд биеэ авч явах байдал нь өөрчлөгдсөн, гадаад (төрөх үеийн хүндрэлүүдийн үлдцийн улмаас 0-3 насанд тэнэгрэх) болон дотоод (хромосомын өөрчлөлт, бодисын солилцоо дутмагшил гэх мэт) шалтгааны улмаас ойлгох, сэтгэх, мэдрэх үйл ажиллагаа нь хязгаарлагдсан хүнийг хамруулна.

Хавсарсан: Нэг хүнд нэгээс дээш төрлийн хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, согог тохиолдвол хавсарсан хөгжлийн бэрхшээлд хамруулна. Жишээлбэл, хөдөлгөөний болон харааны хөгжлийн бэрхшээлтэй хүнийг харааны болон хөдөлгөөний бэрхшээлтэй хүн амд хамруулахгүйгээр хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй хүн амд хамруулна.

Бусад: Ямар нэгэн эмгэг болон өвчний улмаас өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх чадвараа алдсан хүнийг үүнд хамруулна /Тухайлбал, дотор эрхтний эмгэгүүд, хавдар гэх мэт/

